



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10, 2021 оны 11/34 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг дарын 2022 оны “Эрх шилжүүлэх тухай” А/134 дүгээр захирамж, “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Нийслэлийн иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжийг бий болгох, байгалийн сайханд эрүүл орчинд амрах, зугаалах нөхцөлийг бий болгож, гадаад, дотоодын аялагч, амрагчдад мод тарих боломжийг бүрдүүлэх зорилгоор “Нэг жуулчин-Нэг мод” жуулчин төглийг Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд байгуулсугай.

2. “Нэг жуулчин-Нэг мод” жуулчин төглийг байгуулах сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.


3. Ажлын хэсгийг нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг (В.Батчимэг)-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



1150590115

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 06 сарын 16-ны өдрийн
А/34 дугаар тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	В.Батчимэг	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Ц.Тунгалаг	Налайх дүүргийн үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)
	Э.Оргилцэцэг	Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн
	Н.Тамир	Нийслэлийн Байгаль орчны газрын ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, ашиглалт хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
	М.Навчаа	"Цолмон травел" ХХК-ын ийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор)
Нарийн бичгийн дарга:	Б.Жаргалан	Дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн